



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/465

Ховд

Дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Хос мөнх дөл констракшн" ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Ахуйн үйлчилгээний барилгын засвар /Манхан сум/-ын ажилд ашиглагчийн хүсэлтийн дагуу ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй, нэмэлтээр хийгдэх ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Лхагвасүрэн

- Манхан сумын Засаг дарга

Б.Сугар

- "Хос мөнх дөл констракшн" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн
дарга Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга, хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.ЖАРГАЛСАЙХАН

Zah A/465.Kh
02 2471